



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Илчит хутаг ОНӨХХК-ий
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2023/09/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.open.audit.mn Булган аймаг 2024 он	Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Анхбаяр Утас: 7034-2495 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.03.15 № 304

танай _____ ны № _____ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН "ИЛЧИТ
ХУТАГ" ОНӨХХК-ИЙ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Илчит хутаг ОНӨХХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын Илчит хутаг ОНӨХХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Илчит хутаг ОНӨХХК-ний газар сумын Засаг даргын Тамгын газрын эзэмшилд бүртгэлтэй, худалдан авсан үндсэн хөрөнгийг орлого авч бүртгэлд тусгаагүй,

Жолоочийн тооцооны хуудасгүй шатахуун зарцуулсан, зарцуулсан бараа материалыг зарлагадаагүй үлдэгдлээр тайлагнасан, худалдан авсан нүүрсийг хэмжиж пүүлж орлогод авдаггүй, ББӨ-ийг үнэн зөв тооцоогүй, дотоод хяналт сул зэрэг алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлыг хэтэрсэн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 2023 оны XI хуралдааны 15 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийг 7 гишүүнтэйгээр шинэчлэн томилж, гүйцэтгэх захиралд чиглэл өгөх үүргийг компаний дүрэмд тусгаж өөрчлөлт хийсэн байна.

Аудитын гол асуудал

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс нэг ч гишүүн компаний засаглалын сургалтад хамрагдаж, сертификат аваагүй байна.

Бусад асуудлын хэсэг

000020730

Илчит хутаг ОНӨХХК-д ашиглагдаж байгаа ОНХС-аас шилжүүлэн өгсөн хөрөнгийн шийдвэрийг тухай бүр гаргаж, бүртгэлд тусгуулаагүй нь тус компаний ашиг алдагдлыг үнэн зөв тайлагнаагүйг илэрхийлж байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31 мян.төг	2023 оны 12 сарын 31 мян.төг
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	31,347.95	54,203.57
Дансны авлага	15,632.48	36,100.37
Бараа материал	21,875.34	46,433.42
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	2,100.00	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	70,955.77	136,737.36
Үндсэн хөрөнгө	3,788,173.85	3,582,491.57
Бусад эргэлтийн бус хөрөнгө	4,050.00	3,212.00
Нийт эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,792,223.85	3,585,703.57
НИЙТ ХӨРӨНГӨ	3,863,179.62	3,722,440.93
Цалингийн өглөг	-	98.78
Татварын өр	4,230.66	28,601.09
НДШ - ийн өглөг	155.52	-
Бусад богино хугацаат өр төлбөр	48,278.56	16,474.08
Нийт богино хугацаат өр төлбөр	52,664.74	45,173.95
-төрийн	4,405,291.86	4,405,291.86
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,378.19	20,378.19
Хуримтлагдсан ашиг	(615,155.17)	(748,403.08)
Эздийн өмчийн дүн	3,810,514.88	3,677,266.97
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР	3,863,179.62	3,722,440.92

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Үзүүлэлт	2022 он мян.төг	2023 он мян.төг
Борлуулалтын орлого (цэвэр)	567,795.86	719,908.68
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	210,542.01	373,750.14
Нийт ашиг (алдагдал)	357,253.85	346,158.54
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	-	-
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	16,958.40	145,134.09
Борлуулалт, маркетингийн зардал	-	3.18
Ерөнхий ба удирдлагын зардал	579,037.92	549,237.27
Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	1,959.30	40,012.62
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-

Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(204,825.67)	(133,247.90)
Орлогын татварын зардал	-	-
Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(204,825.67)	(133,247.90)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(204,825.67)	(133,247.90)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-	-
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч мян.төг	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл мян.төг	Хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт дүн мян.төг
2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	4,405,291.86	20,378.19	(371,621.17)	4,054,048.88
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(243,534.00)	(243,534.00)
2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	4,405,291.86	20,378.19	(615,155.17)	3,810,514.88
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(132,311.90)	(132,311.90)
2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	4,405,291.86	20,378.19	(747,467.07)	3,678,202.98

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	2022 он мян.төг	2023 он мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Мөнгөн орлогын дүн	647,877.88	958,661.39
Бусад мөнгөн орлого	64,082.02	93,021.82
Мөнгөн зарлагын дүн	638,643.28	935,805.78
Ажиллагчдад төлсөн	180,072.68	213,964.21
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	51,775.67	63,384.01
Бараа материал худалдан авахад төлсөн	139,092.64	370,082.07
Ашиглалтын зардалд төлсөн	154,501.71	83,822.64
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	98,601.90

Татварын байгууллагад төлсөн	71,404.70	79,176.36
Бусад мөнгөн зарлага	41,795.86	23,376.35
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,234.60	22,855.61
Мөнгөн зарлагын дүн	2,181.72	3,398.19
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,181.72	3,398.19
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	7,052.87	22,855.61
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	24,295.08	31,347.95
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	31,347.95	54,203.57

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

Д/д	Үзүүлэлт	Тайлант оны (2023)			
		Бизнес төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	НИЙТ ОРЛОГО	903,205.11	958,661.40	(55,456.29)	106.14
2.1	Өөрийн орлого	876,805.11	957,622.27	(80,817.16)	109.22
2.1.1	Дулаан үйлдвэрлэлийн орлого	773,567.78	740,240.07	33,327.71	95.69
2.1.2	Туслах, ажил үйлчилгээний орлого	55,100.00	32,168.00	22,932.00	58.38
2.1.3	Шугам, сүлжээний цэвэр ус хангамжийн орлого	29,436.53	15,357.20	14,079.33	52.17
2.1.4	Шугам, сүлжээний бохир ус татан, ариутгах орлого	18,700.80	10,457.00	8,243.80	55.92
2.2	Гаднаас авах санхжүүлтийн орлого	26,400.00	26,400.00	-	100.00
2.3	Тендер худалдан авах ажиллагааны орлого	-	133,000.00	(133,000.0)	-
3	НИЙТ ЗАРЛАГА	902,109.94	935,712.18	(33,602.24)	103.72
3.1	Цалин хөлс	252,928.00	257,447.45	(4,519.45)	101.79
3.1.1	Үндсэн цалин	242,790.00	242,790.00	-	100.00
3.1.2	Нэмэгдэл цалин	10,138.00	14,657.45	(4,519.45)	144.58
3.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,616.00	33,012.50	(1,396.50)	104.42
3.3	Ашиглалтын зардал	94,316.94	118,101.40	(23,784.46)	125.22
3.3.1	Цахилгааны зардал	79,757.94	84,758.60	(5,000.66)	106.27
3.3.2	Түлш, шатахууны зардал	14,559.00	40,727.70	(26,168.70)	279.74
3.4	Түүхий, эд материалын зардал	125,276.00	186,983.32	(61,707.32)	149.26
3.4.1	Сэлбэг хэрэгслийн зардал	9,340.00	9,340.00	-	100.00
3.4.2	Нүүрсний зардал	96,000.00	118,372.16	(22,372.16)	123.30
3.4.3	Бичиг хэргийн зардал	960.00	932.90	27.10	97.18
3.4.4	Шуудан, холбоо, интернетийн зардал	2,608.00	2,056.96	551.05	78.87
3.4.5	Хангамжийн материалын зардал	8,688.00	48,601.30	(39,913.30)	559.41
3.4.6	Хоолны зардал	7,680.00	7,680.00	-	100.00
3.5	Хөдөлмөр хамгааллын зардал	15,156.00	13,724.50	1,431.50	90.55

3.5.1	Нормын хувцас	9,780.00	10,498.90	(718.90)	107.35
3.5.2	Хордлого тайлах бүтээгдэхүүн	5,376.00	3,225.60	2,150.40	60.00
3.6	Эд хогшил, урсгал засварын зардал	122,480.00	118,295.70	4,184.30	96.58
3.6.1	Урсгал засварын зардал	93,000.00	94,567.80	(1,567.80)	101.69
3.6.2	Багаж, хэрэгсэл худалдан авах зардал	19,600.00	14,860.00	4,740.00	75.82
3.6.3	Тавилга эд хогшил худалдан авах зардал	9,880.00	8,867.90	1,012.10	89.76
3.7	Томилолтын зардал	2,032.00	2,355.80	(323.80)	115.94
3.7.0	Дотоод албан томилолтын зардал	2,032.00	2,355.80	(323.80)	115.94
3.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	237,705.00	229,583.80	8,121.20	96.58
3.8.1	Нүүрс тээврийн зардал	144,000.00	135,567.80	8,432.20	94.14
3.8.2	Сургалтын зардал	5,130.00	4,146.00	984.00	80.82
3.8.3	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	86,935.00	89,642.00	(2,707.00)	103.11
3.8.4	Хяналт, шинжилгээ, байгаль орчны зардал	1,640.00	228.00	1,412.00	13.90
3.9	Нийгмийн хамгаалал	20,600.00	14,681.90	5,918.10	71.27
3.9.1	Дотоод журмын дагуу олгох тэтгэмж, тусламж	9,000.00	5,681.90	3,318.10	63.13
3.9.2	Шилдэг ажилчдын урамшуулал	6,100.00	3,500.00	2,600.00	57.38
3.9.3	Идэвхжүүлэлтийн зардал	5,500.00	5,500.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,095.17	54,203.50	(53,108.33)	4,949.32
5	Нийт ажиллагсад	30	30	-	100.00
5.1	Удирдах ажилтан	1	1	-	100.00
5.2	Гүйцэтгэх ажилтан	18	18	-	100.00
5.3	үйлчлэх ажилтан	11	11	-	100.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Нийцлийн асуудлаар илэрсэн шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулаагүй, өмнөх оны аудитаар гарсан зөрчлийг давтан гаргасан тул сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

1.Компанид бүртгэлтэй автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-д *“аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй”* үндэслэн албан шаардлага хүргүүллээ.

2.Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 235,993.8 мянган төгрөгийн 23 гүйлгээ мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 109,557.7 мянган төгрөгийн 10 гүйлгээ мэдээлээгүй, тушаал шийдвэрийн 4,734.0 мянган төгрөгийн 9 мэдээллийг мэдээлээгүй, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй дүгнэлээ.

Нийт 95,582.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 21,099.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 74,482.9 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

1.Худалдаж авсан 5,399.0 мянган төгрөгийн 2 ширхэг компьютер, шилжиж ирсэн 3,600.0 мянган төгрөгийн шил бутлагч, багцлагч, 12,100.0 мянган төгрөгийн нэр бүхий үндсэн хөрөнгүүдийг орлогод аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл *"Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт"*, 14 дүгээр зүйл *"Нягтлан бодох бүртгэл хөтлөх"* заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д *“Нягтлан бодох*

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бүртгэлийн холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” заалтыг үндэслэн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүллээ.

2. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2023 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 06/24 дугаар албан бичгээр ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-т “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлагыг нийцлийн аудитын асуудлын хүрээнд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хамтатган хүргүүллээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, 6 гишүүн нь засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаагүй байна. Энэ нь Компаний тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8 дахь заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарыг компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамруулж, гэрчилгээ авсан байх.

Илрүүлэлт: Нүүрс хүлээн авахдаа пүүлж хэмжихгүй орлогод авч байгаагаас батлагдсан зорилтод түвшний нүүрсний зардлыг хэтрүүлэн зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авсан бараа материалыг бүртгэлд тусгахдаа үнэн зөв бүрэн бүтэн байдлыг шалгаж, дотоод хяналтыг сайжруулан ажиллах.

2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг сумын ИТХ-аар батлуулахдаа компаний ашиг алдагдлыг тооцож батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг батлуулах, ашиг алдагдал, элэгдлийн зардлыг тооцоолж, биелэлт хангагдахуйц байхаар батлуулж ажиллах.

3. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын тайлангийн хангамж материалын дансанд тендерын ажилд зарцуулсан 4,372.7 мянган төгрөгийн 37 ширхэг леги блокыг

үлдэгдэлтэй тайлагнасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг шаардах хуудсыг үндэслэн зарлагын баримтыг тухай бүр үйлдэж, агуулах бүртгэлийг үнэн зөв хөтөлж тайлагнаж хэвших.

Илрүүлэлт: Нүүрс хүлээн авахдаа пүүлж хэмжихгүй орлогод авч байгаагаас батлагдсан зорилтод түвшний нүүрсний зардлыг хэтрүүлэн зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авсан бараа материалыг бүртгэлд тусгахдаа үнэн зөв бүрэн бүтэн байдлыг шалгаж, дотоод хяналтыг сайжруулан ажиллах.

4. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: НӨАТ-гаар тайлагнасан борлуулалтын орлогын дүн нь орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлантай зөрүүтэй байгаа нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татвар ногдуулах орлогыг үнэн зөв тодорхойлж, тайлагнаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		НББ-ын бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга хийгдээгүй.												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн											
Худалдаж авсан 2 ширхэг компьютер, шилжиж ирсэн шил бутлагч, багцлагч, үндсэн хөрөнгүүдийг орлогод аваагүй.	1	21,099.8			1	21,099.8							
Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, 6 гишүүн нь засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаагүй.	1	-					1	-					
Нүүрс хүлээн авахдаа пүүлж хэмжихгүй орлогод авч байгаагаас батлагдсан зорилтод түвшний нүүрсний зардлыг хэтрүүлэн зарцуулсан.	1	-					1	-					

Бараа материалын тайлангийн хангамж материалын дансанд тендерын ажилд зарцуулсан материалыг үлдэгдэлтэй тайлагнасан.	1	4,372.7				1	4,372.7					
НӨАТ-гаар тайлагнасан борлуулалтын орлогын дүн нь орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлантай зөрүүтэй.	1	70,110.2				1	70,110.2					
Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг сумын ИТХ-аар батлуулахдаа компаний ашиг алдагдлыг тооцож батлуулаагүй.	1	-				1	-					
Дүн	6	95,582.7			1	21,099.8	5	74,482.9	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Илчит хутаг ОНӨХХК	1	1				1		
	ТШЗ-ийн дүн	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

